



Энэтхэгийн туршлага

Хог хаягдал гэдэг бидний хэрэглээнээс үүдэлтэй бөгөөд эдийн засаг, нийгмийн хөгжлийг дагаж гарч ирсэн боловч эргээд нийгэм, эдийн засаг, байгаль орчны аль алиных нь тулгамдсан асуудал болоод байгаа билээ. Энэ сэдвийг бусад орнуудын сургуулиудад хэрхэн заадаг талаар цуврал байдлаар хүргэж байна.

ШАТААХ УУ ЭСВЭЛ...?

Хичээл хоорондын холбоо: экологи, биологи, нийгэм, эрүүл мэнд

Зорилго: шатаж буй хог хаягдлын хор нөлөөг олж мэдэх

Аргачлал:

1. Сурагчдаас шатаж буй хогийн (хогийн цэг дээр, цэцэрлэгт, сургуулийн хашаанд) хажуугаар явж байсан эсэхийг нь асуугаарай. Мөн сурагчдаар яагаад хог хаягдлыг шатаадаг шалтгааныг хэлүүлнэ. Магадгүй дараах зарим нэг шалтгааныг ч тэд хэлж болох юм.

- Хатуу хог хаягдлыг устгах тодорхой газар байдаггүй.
- Хатуу хог хаягдлыг цуглуулах тогтолцоо байдаггүй.
- Устгахын тулд хог хаягдлыг хол газар зөөж тээвэрлэх шаардлага гардаг.
- Хог хаягдал нь эргэн тойронд амархан тархаж орчин тойрныг бохирдуулдаг.
- Хамаагүй холилдсон хогийг шатаахад метал хаягдлууд нь амархан ялгарч түүж авахад хялбар болно.
- Хог хаягдлыг шатааснаар хогийн цэг дээр шувуу болон янз бүрийн амьтад цуглахгүй байх урьдчилсан ноцол бүрдүүлэхэд тустай.

Хог хаягдлыг шатаах нь нэг талдаа хэрэгтэй мэт боловч нөгөө талаас энэ нь тэр хатуу хог хаягдлыг хийн байдалтай хог болгон өөрчилж өөр нэг төрлийн бохирдол буюу агаарын бохирдлын эх үүсвэр болдог.


2. Сурагчидтай хог хаягдлыг задгай шатааснаас гарах бэрхшээлтэй асуудлууд, тэдгээрийг шийдэх боломжит арга замын талаар ярилц.

- Хог шатаахад утаа нь хаашаа явдаг вэ? Энэ нь агаарын бохирдол мөн үү?
- Агаарт их хэмжээний утаа, жижиг хэсгүүд байхад юу болох вэ?
- Хүний эрүүл мэндэд ямар нөлөө үзүүлэх вэ? Орчин тойрны харагдах бараанд нөлөөлөх үү?
- Шатаж дууссаны дараа үлдэж байгаа үнсийг яадаг вэ? Яах ёстой вэ?
- Хогийг шатаах үед ялгарч байгаа дулааныг оор зүйлд ашиглаж болох уу? Хэрхэн, яаж?

Хог хаягдлын байгальд үзүүлэх сөрөг нөлөө, хор нөлөөгүй шатаах боломж, тохиромжтой бүтэц үйл ажиллагаатай хог шатаах төхөврөмжийг зүй зохисоор нь ашиглах талаар тайлбарла. Тухайлбал, агаар болон орчин тойрныг бохирдуулахгүйгээр хог хаягдлыг устгах эдийн засгийн хувьд ашигтай ямар арга байж болох талаар харилцан ярилц. Жишээ нь: унасан навч, гал тогооны хаягдлыг бордоо болгож ашиглах, мөн төрөл бүрийн цаас, даавуу, хуванцар болон шил савнуудыг дахин боловсруулж болох юм.

3. Хот суурин газар амьдардаг хүмүүс эдгээр зүйлсийг яагаад хийхгүй байна гэж та нар боддог вэ? Хүмүүст хатуу хог хаягдлыг хор хөнөөлгүй хэрхэн устгах арга замыг зааж өгөх зайлшгүй шаардлага бий юу? Танай хотын удирдлагууд энэ тал дээр ямар ямар арга хэмжээ авдаг вэ? Хүүхдүүд энд ямар үүрэгтэй оролцож болох вэ?

Энэтхэгийн "Тогтвортой хөгжлийн Боловсрол" яврын нөлөөг нэмжээс орчуулав / Л. Алтанцэцэг - Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол Дижитал Бичиг хөтөлбөрийн газрын Алтай Соёлы бүсийн салбарын мэдээлэл сурталчилгаа, байгаль орчны боловсрол зориулсан ажилтан /



АСУУЛТЫН ХЭВ МАЯГ

(Өмнөх арга зүйн хичээлийн үргэлжлэл).

1. Танил болох зуучлагч асуултууд

А. Анхаарал төвлөрүүлэх асуултууд

Хамгийн энгийн судлан, шинжлэх асуулт нь судалж буй зүйлд сурагчдын анхаарлыг хандуулна. Тө нэр чийгийн улаан хорхойны толгой, сүүлийг ялгаж чадах уу?

Чийгийн улаан хорхой арагшаагаа яаж чадах уу?

Тэр яаж явдаг (хөдөлдөг) вэ?

Б. Тоолох, хэмжих асуултууд

Тоо, хэмжээ бол бусад сурагчдын хийсэн ажиглалттай амархан харьцуулах замаар мэдээлэл олж авах сайн арга юм. Энэ нь тодорхой жижиг зүйлд сурагчдын анхаарлыг төвлөрүүлэхэд тусална.

Чиний сонгосон чийгийн

улаан хэр (хэдэн см) урт вэ?

Тэр хэр хурдан явдаг вэ?

В. Харьцуулах асуулт

Сурагчдаар ажиглалт хийлгүүлэх, үнэлгээ өгүүлэх нь тэдэнд өөрсдийнхөө судалж буй зүйлд итгэл, найдвар төрүүлэх чухал хандлага юм.

Чийгийн улаан хорхойны гэдэс нуруу адилхан уу?

Чийгийн улаан хорхой хоорондоо юугаараа ялгаатай юм бэ?

Г. "Хэрэв ... тэгвэл яах бол?"

"Хэрэв ... ингэвэл яах бол?" зэрэг асуултууд нь энгийн туршилт явуулахад ихэвчлэн хэрэглэдэг. Ингэснээр, сурагчид юмыг урьдчилан таамаглах дадал, чадвараа хөгжүүлдэг байна.

Хэрэв чийгийн улаан хорхой нуруугаараа дээш харчихвал яах бол?

Хэрэв тэр ямар нэг исгэлэн зүйлд хүрчихвал юу болох бол?

2. Судалгааны асуултууд

Судлан шинжлэх асуултад хариулт өгөхийн тулд та судалгаа явуулах хэрэгтэй болно. Энэ нь судлах зүйлтэйгээ танилцахыг шаардана. Энэ үүднээс судалгааны асуулт явуулахын өмнө энгийн хэлбэрийн асуултуудыг тавих хэрэгтэй. Судалгаа хийх ерөнхий зарчмуудыг ойлгож, практикт ашиглах нь ихээхэн ач холбогдолтой.

Асуултаа тодорхойл. Чийгийн өтнүүд хүнсний ямар хаягдалд дуртай байдаг вэ?

Өөрчлөлт, хувьслуудыг тодорхойл. (Температур, чийг, хорхойны тоо, хаягдлын тоо).

Юуг хэмжиж, харьцуулах ёстой вэ?

Үр дүнтэй холбоотой ямар тайлбар өгөх вэ?

Хүнсний үлдсэн хаягдлын тоо хэмжээг харьцуул.

А. Асуулт тавих

Сурагчид өөрсдөө хариулт олох, тэдний сонирхол хүслийг улам бадраах асуулт байна.

Б. Таамаглал дэвшүүлэх

Энэ нь сурагчдад бодитойгоор гарган авсан үр дүнд урьдчилан дэвшүүлсэн таамаглалтайгаа харьцуулахад тусална.

В. Судалгаа шинжилгээ

Ямар материал хэрэгтэй вэ?

Судалгаа яаж явагдах ёстой вэ?

Ямар хувьсал өөрчлөлтүүдийг тэмдэглэх вэ?

Г. Үр дүн

Үр дүнг яаж тайлбарлаж болох вэ?

Бид шинэ судалгаа шинжилгээ явуулах ёстой юу?

Д. Дүгнэлт

Таамаглал үнэн зөв байв уу?

Судалгааны үр дүн шинэ асуудал дэвшүүлж байна уу?

Оновчтой таамаглал дэвшүүлэх буюу туршилт явуулах дадлага туршлага дутагдах явдал сурагчдын дунд ажиглагддаг.

Зөв томъёологдсон судалгааны асуулт зөв үедээ тавигдсан тохиолдолд үр дүнтэй байдаг.

Хүнсний ямар хаягдалд чийгийн улаан өт илүүд дуртай байдаг вэ?

Хүнсний хаягдлаас хэдий хирийн шороо бий болох вэ?

Бид бордоо болгох замаар хүнсний хаягдлын хэмжээг хэдий хэр бууруулж чадах вэ?

Иймэрхүү асуултууд нь ажлыг идэвхжүүлэн, бодож сэтгэх, хэлэлцэхэд түлхэц өгдөг. Сурагчид их туршлага хуримтлуулахын хирээр хэцүү бэрх онолыг бий болгож чадна.



Энерги дамжуулах буухиа

Зорилго: Хоол хүнсний гинжин холбоогоор энерги хэрхэн алдагддаг талаар оролцогчдод ойлгуулахад туслах

Чиглэл: Хүрээлэн буй орчин
Насны түвшин: Дунд нас
Хичээл: Шинжлэх ухаанч
Үргэлжлэх хугацаа: 30 минут
Оролцогчдын тоо: 60 буюу түүнээс дээш
Тоглох газар: Гадаа буюу дотор орчинд
Чадвар: Багаар ажиллах
Хэрэглэгдэхүүн: 2 ширхэг ижил хэмжээтэй аяга, халбага, хэмжигч цилиндр



Заввар: Оролцогчдыг ойролцоогоор 15 тоглогчидтой байхаар нэг эгнээнд зогсооно. 15-аас илүү байвал хоёр эсвэл гурван эгнээ болгоно. Нэг аяга ус авч эгнээ бүрээс 2-3 оролцогчдыг гаргаж ирэн хэмжигч мензуркээр аягатай усны хэмжээг тодорхойлуулна. Тэгээд уг аягатай усаа хүн бүрт харагдахаар эргүүлж тойруулан үзүүлж усны хэмжээг тэмдэглэн авна.

Эгнээний хамгийн эхэнд зогсож байгаа оролцогчид халбага болон хэмжсэн аяга ус хоёрыг өгнө. Харин хамгийн сүүлийн оролцогчид хоосон аяга, халбага бас өгнө. Эгнээнд зогсож буй бүх оролцогчдод халбага тарааж өгөх хэрэгтэй. Эхний оролцогч аягатай уснаас халбагандаа хийн хоёр дахь оролцогчид дамжуулна. Гэх мэтчилэн цааш нь дамжуулсаар хамгийн сүүлд зогсож байгаа оролцогч халбагатай усыг хүлээн авч өөрийн барьж байсан аяганд юүлнэ. Аяганд байгаа ус хамгийн сүүлчийн оролцогчийн аяганд бүрэн юүлэгдсэний дараа хоёр оролцогчийг дуудан гаргаж ирээд уг юүлэгдсэн аягатай усыг мензуркээр хэмжүүл. Дараа нь хүн бүрт харагдахаар аягатай усыг эргүүлж тойруулан түүн доторх усны хэмжээг тэмдэглэнэ.

Хувилбар: Эгнээ тус бүр баг болж тоглож болно. Дараа нь хамгийн бага ус асгасан багийг шалгаруулах "энерги дамжуулах буухиа" тэмцээн явуулж болно. Тоглоомыг хоёр үетэй тоглож болох бөгөөд энэ үед оролцогчид усныхаа асгарах хэмжээг улам багасгахыг хичээх болно.

(Жин: Аягай доторх усыг гаднаас нь харан боловчтой аж гэнэх нь тохиромжтой)

Шийдэл:

Алдагдсан буюу асгасан нэг халбага ус юуг илэрхийлэх бол?

Халбага ус бүр энергийн хэмжээг төлөөлж байгааг тайлбарлаж мөн дамжуулж буй энерги бүхэн дамжуулалтын явцад хэрхэн алдагдаж буйг тайлбарла

Хэн хаана хамаарах вэ?

Чиглэл: Хүрээлэн буй орчин
Насны түвшин: Бага, дунд нас
Үргэлжлэх хугацаа: 30 минут
Оролцогчдын тоо: Ойролцоогоор 20 хүн
Тоглох газар: Дотор буюу гадаа
Чадвар: Харилцаа холбоогоо хөгжүүлэх
Хэрэглэгдэхүүн: Амьдралын сүлжээг харуулсан картууд (цагаан хар гэсэн талтай картууд байна), хөгжмийг орлуулах ямар нэг зүйлс (халбага, хонх, лонх, аяга гэх мэт). Карт бүр дээр тухайн орчинд хамааралтай амьд амьгүй зүйлсийн нэрийг бичсэн байна.

Зорилго: Тоглогчдод янз бүрийн орчны талаар суралцахад туслана.

Заввар: Оролцогчид тойрог болж зогсоно. Тойргийн гадна талд ус намгархаг газар, хөрс шороо, ой мод, хот суурин газар гэсэн янз бүрийн орчныг тэмдэглэсэн дөрвөн булан бий болгоно.

Эдгээр орчныг шохойгоор газарт тэмдэглэх юм уу эсвэл дөрвөн буланд дээрх орчны нэрсийг бичиж байрлуулна. Амьдралын сүлжээ болох картуудаа оролцогчдод тараан өгнө. Тэдэнд зөвхөн хар буюу цагаан талыг хэрэглэнэ гэдгийг хэлнэ. Оролцогч бүр ганц карт авах ёстой.

Хөгжим эхэлмэгц оролцогчид картаа баруун гар талд байгаа хүнд зэрэг дамжуулна. Хөгжим зогсонгуут оролцогч бүр өөрт ирсэн картан дээрх нэрийг харж, хамааралтай орчин руугаа очиж зогсоно. Тэгээд хүүхдүүд яагаад энэ орчинд хамааралтай болохыг хоорондоо ярилцана. Мөн бусад орчинд байгаа хүүхдүүдийн саналыг сонсоно.

Хувилбар: Ус намгархаг газар, хөрс шороо, ой мод, хот суурин газар гэсэн дөрвөн орчинг тойргоор үүсгэнэ.

Өөр нэг тойрог дотор дээрх орчнуудад хамааралтай зүйлсийг бичсэн картуудыг байрлуулсан байна. Хөгжим дуугарч эхэлмэгц хүүхдүүд тойргийн гадуур, баруун гар тал руугаа явж байгаад хөгжмийн ая зогсмогц тойрог



дотроос нэг карт сугалж авна. Тэгээд картаа уншаад хамааралтай орчин руугаа очиж зогсоно. Дараа нь хоорондоо ярилцана.

Шийдэл:

Бүх амьтад, ургамлууд өөрсдийнхөө хамааралтай орчиндоо байна уу үгүй юу? (Хүүхдүүд өөрсдийнх нь сонгож авсан орчин зөв эсэхийг сайн бодож хариулна) Яагаад амьтад, ургамлууд энэ орчинд зөвхөн амьдардаг вэ? Орчин нь амьтан, ургамлын хувьд юугаараа онцлог вэ?

Орчин тус бүрт байдаг төрөл зүйлүүдийн дунд ямар харилцаа холбоо байна вэ?

Хэрвээ аль нэг орчин үгүй болж уствал төрөл зүйлүүд нь яах вэ? Тэдэнд юу тохиолдох бол?

Санаа тавих ба хуваалцах

Чиглэл: Тогтвортой хөгжил

Насны түвшин: Дунд нас

Хичээл: Нийгэмшихүйн ухаанд суралцах, ёс суртахууны хэм хэмжээ

Үргэлжлэх хугацаа: 15 минут

Оролцогчдын тоо: 60 буюу түүнээс дээш

Тоглох газар: Дотор буюу гадаа орчинд

Чадвар: Хэсгээр хамтран ажиллах

Зорилго: Нийтлэг зорилгод хүрэхийн төлөө хамтран ажиллаж, харилцан саналаа солилцохын чухлыг оролцогчдод ухамсарлуулахад туслана.

Заавар: Нэг хэсэгт ойролцоогоор 10-15 тоглогчид байхаар хүүхдүүдийг хэд хэдэн хэсэгт хуваана. Энэ тоглоомонд хэсэг бүрт байх хүүхдийн тоо тэнцүү байна. Уг тоглоомонд тэд зөвхөн биедээ өмссөн зүйлсийг ашиглах бөгөөд өөр бусад зүйлс хэрэглэхийг зөвшөөрөхгүй.

Тоглоом эхлэхэд бэлэн болмогц хэсэг бүр улс орныг төлөөлнө шүү гэдгийг хэлж өгнө. Ямар улс орон болохоо хэсэг бүр өөрсдөө шийднэ.

Хэсэг бүрийн зорилт бол шулуун зам үүсгэх явдал юм.

Уг шулуун замын уртын хэмжээ нь Улс орон Тогтвортой хөгжил рүү явж байгааг илтгэнэ. Хэсэг бүр шулуун замын дагуу зөвхөн өөрсдийнхөө өмсөж байгаа хувцас, зүйлсийг тавьж, урт шулуун үүсгэх юм. Уралдах хугацаа 60 секунд. Хамгийн урт шулуун зам үүсгэсэн хэсэг (улс орон) тус тоглоомод ялагч болно.


Шийдэл:

Нийтийн үйл хэрэгт оролцох нь ямар ач холбогдолтой вэ?

Хүн бүрийн хувь нэмэр Тогтвортой хөгжилд чухал нөлөөлөл үзүүлж чадах уу?

Багаар хамтран ажиллах нь чухал уу? Яагаад?

Хамтын ажиллагааны хүрээнд болон улс үндэстнүүдийн хооронд байгаль орчны асуудлыг шийдэж болох уу?



(Энэ удаагийн дугаарт Өвөрхангай, Дорнод аймгийн үндэсний сүлжээний сургагч багш нарын боловсруулсан нэг өдрийн сургалтын хөтөлбөрийг танилцуулж байна.)

Сэдэв: Хог хаягдал

Боловсруулсан: Өвөрхангай аймгийн сургагч багш нар
С.Баярбат, Ж.Наранциралт, Б.Бадам, Н.Доржнямбуу

Үндэслэл: Хувь хүний хувьд: Эрүүл, аюулгүй орчинд амьдрах, эрүүл, аюулгүй байх хэрэгцээ шаардлага
Нийгмийн хувьд: Экологийн аюулгүй байдлыг хангах эдийн засгийн зохистой харилцаа бий болгох, үйлдвэрлэлийн технологийг боловсронгуй болгох.

Зорилго: Хог хаягдлыг ангилах, боловсруулах, ашиглах, устгах арга замд суралцах.

Зорилт:

1. Хог хаягдал гэж юу болох талаар ойлголтоо баяжуулах
2. Хог хаягдал үүсэж буй нөхцөл шалтгаан, хог хаягдлын төрөл зүйлийг ялган таних
3. Хог хаягдлаас болж үүдэж буй эрүүл мэндийн болон экологийн сөрөг үзэгдлүүд
4. Хог хаягдлын ашиглах, дахин боловсруулах боломж, нөхцлүүдийг тодорхойлох.
5. Өөрийн амьдарч буй орчны хог хаягдлын байдалд дүгнэлт хийх, ангилах, дахин боловсруулах, устгах.

Дээрх зорилтуудыг танхимын болон танхимын бус сургалтаар хэрэгжүүлнэ.

1-р үе:

2-р үе:

Танхимын бус сургалтаар 5-р зорилтыг хэрэгжүүлэх дадлага ажлыг зохион байгуулна.

Зорилт: Өөрийн амьдарч буй орчны хог хаягдлын байдалд дүгнэлт хийх, иргэдийн ёс суртахуун, ухамсарт нөлөөлөх, хог хаягдлыг ангилах, дахин боловсруулах, устгах.

Үйл ажиллагаа:

- Өөрийн оршин амьдарч буй орчинд хогжилтын түвшинг тогтоох судалгаа хийнэ.
- Гүйцэтгэж буй дадлага ажилтай холбоотой тоглоом тоглоно. Тухайлбал "Замын тэмдэглэл"
- Хог бүхий цэгүүдэд тухайн хог ямар эх сурвалжтай, хэдэн төрөл, зүйл болох, төрөл зүйл бүрийн хүний эрүүл мэнд болон экологийн аюулгүй байдалд үзүүлж буй сөрөг нөлөөг тодорхойлно.
- Төрөл зүйлээр ялгасан хогийг боловсруулалтанд орж болох эс орж болохоор нь ялгалт хийнэ.
- Боловсруулалтанд орж болох хог хаягдлыг ямар аргаар ямар шатны боловсруулалтанд орж болохыг тогтооно.
- Энгийн аргаар боловсруулж болох хог хаягдлыг боловсруулах, ашиглах, технологи, зааврыг гаргана.

Гүйцэтгэх хугацаа: 13.00-15.00

Цайны цаг: 16.00-16.20

1-р үе шат: Танхимын сургалтын явц

№	1	2	Цайны цаг
Мэдлэг эзэмшихүйн үе шат	Мэдлэг беримжаалах үе шат	Шинэ мэдлэг эзэмших	
Зорилт		3.Хог хаягдлаас үүдэж буй эрүүл мэндийн болон экологийн сөрөг үзэгдлүүдийг ярилцах	
Үйл ажиллагаа, түүнийг зохион байгуулах арга зүй	Балшийн	Хог хаягдал хэрхэн бий болж буйг харуулсан видео бичлэг үзүүлэх	Өөрсдийн мэдэх эрүүл мэндийн болон экологийн хор холбогдол бүхий хог хаягдлыг жагсаалт гарган тэрч, түүний хор холбогдлыг зарчлалын аргаар тодорхойлох.
	Суралцагчийн	-Видео бичлэгийг үзээд хог хаягдал гэж юу болох, түүний үүсэж буй нөхцөл шалтгаануудыг жагсаалт гаргах аргаар тэмдэглэл хөтлөн тодорхойлох.-Хог хаягдлын эх сурвалж үүсэж буй нөхцөл шалтгаан төрөл зүйлийг зэрэг-тэлийн аргаар тодорхойлох.	Хог хаягдлаас болж үүдэж буй эрүүл мэндийн болон экологийн сөрөг үзэгдлүүдийн талаар тодорхой баримтуудыг дурдаж мэдээлэл хийнэ. -Баримт, мэдээлэлдээ видео бичлэг, зурагт үзүүлэн ашиглана.
Анги зохион байгуулах хэлбэр	Балшийн үйл ажиллагааны үед нийтээр суралчийн үйл ажиллагааны үед ганцаарчилсан	Балшийн үйл ажиллагааны үед нийтээр суралчийн үйл ажиллагааны үед ганцаарчилсан	
Хичээл зохион байгуулах хэлбэр	Семинар	Семинар	
Цаг хуваарилалт	40 минут 9.00-	60 минут 9.40-10.10	10.40-11.00

Мэдлэг эзэмшихүйн үе шатны 3-рт мэдлэг бүтээх үе шат юм. Зорилт нь хог хаягдлыг ашиглах, дахин боловсруулах боломж арга замуудыг тодорхойлно.

4-рт мэдлэг хөгжүүлэх буюу хэрэглээ болгох үе шат юм. Зорилт нь өөрийн амьдарч буй орчны хог хаягдлын байдалд дүгнэлт хийх, иргэдийн ёс суртахуун ухамсарт нөлөөлөх, хог хаягдлыг ангилах, боловсруулах, устгах.

3-р үе:

Дүгнэлт:

- Баг бүр танхимын бус сургалтаар хийсэн дадлага ажлынхаа тайланг тавина.
- Илтгэгчийг тоглоомын аргаар тодруулна.
- Баг бүрийн дүгнэлтийг ашиглан орон нутгийн хогны асуудлаар Ирээдүйн тухай төсөөллийн 4 хувилбар боловсруулна.
- Суралцагчдыг "Ирээдүйн тухай 4 төсөөлөл" дасгал дээр ажиллуулна.

Гүйцэтгэх хугацаа: 16.20-18.00

Багш нарын туршлага

Сэдэв: Элсний нүүдэл

Боловсруулсан: Дорнод аймгийн сургаач багш нар Х.Баясгалан, Б.Уранжаргал, С.Байгальмаа, А.Туяа

Хамрах хүрээ: Булган сумын дунд сургуулийн мэрэгжлийн багш нар болон эцэг эхийн төлөөлөл, төрийн ба төрийн бус байгууллагын төлөөлөл

Хэрэгцээ: Тус сумын нутагт сүүлийн 2-3 жилд элсний нүүдэл эрс нэмэгдсэн ба элсний нүүдлийг зогсоох багасгах зайлшгүй хэрэгцээ шаардлага гарч ирсэн. Үүнийг хэрэгжүүлэхийн тулд тус сумын нутагт ажиллаж амьдарч байгаа ирэгдийн оролцоог нэмэгдүүлэх хамтарч ажиллах хэрэгцээ

Сургалт явуулах орчин: Дорнод аймгийн Булган сум
Хугацаа: 9.00-15.00

Сургалтын зорилго:

- Байгаль орчны тулгамдсан асуудлуудыг тодорхойлох
- Булган суманд байгаль орчны талаар тулгамдаж буй асуудлыг дэвшүүлэн, шийдвэрлэх арга замыг тодорхойлох
- Элсний нүүдэл үүсэх шалтгааныг тодорхойлж, багасгах арга замыг хамтран хэлэлцэж хэрэгжүүлэх



Сургалтын арга: Асуудал дэвшүүлэн шийдвэрлэх, санал сонголт хийх, жагсаалт гаргах, эрэмбэлэх, чухлыг сонгох, дүн шинжилгээ хийх, дасгал, кино үзэх, төсөл бичих

Үйл ажиллагаа

1. Танилцуулга

Байгаль орчны боловсрол Ногоон сургууль дэд төслийн зорилго, зорилт, үйл ажиллагааг оролцогчдод танилцуулах

2. Байгаль орчны тулгамдсан асуудлуудыг тодорхойлох дасгал ажиллах

Багуудад дараах дасгалын хуудсуудыг тарааж өгнө.

- А.
- Дэлхийн байгаль орчинд тулгамдсан асуудлуудыг жагсааж бич
 - Монголын байгаль орчинд тулгамдсан асуудлуудыг жагсааж бич
 - Танай сумын байгаль орчинд тулгамдсан асуудлуудыг жагсааж бич

Б. Эдгээр асуудлуудаас хамгийн чухалыг сонгуулж харилцан ярилцуулж мэдээлэл өгнө.

3. Сүүлийн үед дэлхийн хэмжээнд тулгамдаж буй асуудал болох "Дэлхийн дулаарал", кино үзүүлж хэлэлцэж харилцан ярилцана

4. Булган сумын байгаль орчинд тулгамдсан асуудлуудыг тодорхойлох дасгал ажиллах

А. Булган сумын байгаль өнгөрсөн үед

Б. Булган сумын байгаль одоо үед

В. Булган сумын байгаль ирээдүйд

Эндээс хамгийн их тулгамдаж байгааг 1, 2, 3, 4, 5, 6 гэж дугаарлуулж нийтээрээ харилцан ярилцаж **Цолжилт** гэдэг санааг гаргаж ирнэ

5. "Цолжилт" гэсэн мэдээлэл өгөх, кино үзүүлэх, дасгал ажиллуулах

Дасгал: Хэрэглэх материал, заавар

-3м хэмжээтэй гялгар цаасан дээр элсийг манхан байдлаар овоолж асгана. Элсрүүгээ салхин сэнсээр үлээлгэнэ. Эндээс элсний нүүдэл явагдах үйл явцыг ажиглуулж дүгнүүлэх, сэргийлэх арга замыг тодорхойлуулах. /Жилд 1-2 м нүүнэ/

6. Төсөл бичих аргачлал

7. **Дүгнэлт.** Сургалт зорилгодоо хүрсэн эсэх үр дүнг дүгнэж ярилцана.

8. **Сургалтын талаарх санал асуулга авна.**

Сургалтын чанар (а. хангалттай сайн, б. хангалттай, в. хангалтгүй)

9. а. Алжаал тайлах дасгал

Экологийн тойрог: Оролцогчид тойрог болно. Удирдагч баруун гар тийш эргүүлж тойргийг нягтруулна. Оролцогчидоор **экосистемийн холбогдолтой нэр** хэлүүлнэ. Дараа нь оролцогчдыг өвдгөн дээрээ хагас суухыг зөвлөнө. Одоо ард байгаа хүний өвдгөн дээр нэгэн зэрэг сууна. Удирдагч **нар** болсон хүн байна уу гэж асуугаад **Нар мандаж байгаа мэт** гараа дээш доош болгож үзүүлэхийг хүснэ. Нар болсон оролцогчийг тойргоос гаргаж **Нар хиртлээ** гэж хэлнэ. Байгалийн юмс үзэгдэл болсон оролцогчийг ийм маягаар тойргоос гаргана. Дүгнэлт: Байгалийн юмс үзэгдэл устаж алга болбол Байгаль экосистемд яаж нөлөөлөх тухай танин мэдэхүйн асуултанд хариулж дүгнэн ярилцана.

10. **Сертификат гардуулах** (Бие биедээ элэгсгээр мэндчилж гардуулна)

Хагас өдрийн сургалтын хөтөлбөр: Үйл ажиллагааны дараалал, хугацаа, зохион байгуулагч зэрэг сургалт явуулах төлөвлөгөөг гаргана.

Байгаль орчны мэдээ

МИНИЙ СОНГОЛТ- ГЯЛГАР УУТГҮЙ ЦЭВЭР ОРЧИН

2006-12-26



Дэлхийн Байгаль Хамгаалах Сан (WWF)-гийн Монгол дахь Хөтөлбөрийн газрын санаачил-гаар Гялгар уутны хэрэглээг багасгах 7 хоногийн хөтөлбөрийг Номин

Холдинг групптэй хамтран Номингийн 2 салбарт, тухайлбал, Улсын их дэлгүүрийн супермаркет болон 3, 4-р хороололд байрлах Номин плаза дэлгүүрийн супермаркетэд энэ сарын 25-наас 31-хүртэл зохион байгууллаа. Уг үйл ажиллагааг 2006 оны 12 сарын 25-ны өдрийн 15 цагт Улсын их дэлгүүр дэхь Номингийн супермаркет -д нээлээ.

“Хариуцлагатай уул уурхай ба хорт бодисын зохистой хэрэглээ” сэдэвт бүсийн семинар зохион байгууллаа

2006-11-20.

Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газар нь УИХ-ын Байгаль орчин, хvнс, хөдөө аж ахуйн байнгын хороо, Байгаль орчны яамтай хамтран “Хариуцлагатай уул уурхай ба хорт бодисын зохистой хэрэглээ” сэдэвт бүсийн семинарыг 2006 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр Дархан-Уул аймгийн Дархан хотод зохион байгууллаа.

2006-10-16. Уралдаан зарлаж байна.

БСШУЯ, БОЯ, Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газар хамтран бүх аймгуудын Боловсрол соёлын газрууд, Нийслэлийн боловсрол шинжлэх ухааны газрын хооронд “Байгаль орчны боловсрол ба тогтвортой хөгжил” сургалт зохион байгуулах уралдаан зарлаад байна.

Дэлгэрэнгүйг www.wwf.mn-гоор үзнэ үү.

RAMBOLL

Ramboll Natura AB

2006-11-15. Бөхөнг хулгайгаар хөнөөдөг бүлэг анчдыг илрүүлэв.

2006 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр Ховд аймгийн Чандмань сумын иргэн Гончиг овогтой Алтангэрэлийн ЗИЛ-130 маркийн УБМ 92-39 дугаартай машины запас дугуйнд монгол бөхөнгийн 54 хос буюу 108 ширхэг эвэр хууль бусаар нууж авч явсныг илэрвүүлээ.



2007-01-12. Аймгуудын боловсрол соёлын газрын дарга нартай уулзалт зохион байгуулав.

БСШУЯ-аас зохион байгуулж байгаа сургалтын үеэр аймаг, нийслэлийн Боловсрол Соёлын Газруудын дарга нарт Тогтвортой хөгжлийн “Байгаль орчны боловсрол” дэд төслийн явц, цаашдын зорилтын талаар Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газрын байгаль орчны боловсролын асуудал хариуцсан ажилтан Ч.Эрдэнэчимэг мэдээлэл хийж санал солилцлоо.



ГЯЛГАР УУТНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛӨЛ

Гялгар уут нь,

Зодралд орохдоо маш удаан, дунджаар 100-500 жил, зарим тохиолдолд хэзээ ч задардаггүй.

- Өнөөг хүртэл задралын хугацааг нарийн гаргаагүй
- Учир нь, хуванцрын түүхэн замнал маг богино, энэ төрлийн бүтээгдхүүнийг саяхан гаргаж авсан.



Орчны бохирдлын эх үүсвэр болох нь:

- Орчны үзэмжийг гутаана.
- Шатаахад диоксин, фуран зэрэг хорт хавдар үүсгэгч химийн хорт нэгдлүүдийг ялгаруулдаг.



Дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийг түргэсгэгч сөрөг үр дагавартай:

- Уур амьсгалын өөрчлөлтийг түргэсгэгч хийн нэгдлүүд болох нүүрстөрөгчийн давхар исэл болон метаныг агаарт ялгаруулна.
- Гялгар уут нь нефтийн үйлдвэрлэлийн дагавар бүтээгдхүүн тул өөртөө их хэмжээний нүүрстөрөгчийг агуулдгийг мартаж болохгүй.

CO₂, CH₄
ХҮЛЭМЖИЙН
ХИЙ

Ан амьтны үхлийн шалтгаан болох нь:

- Ан амьтны ходоод гэдсэнд идэш тэжээлээр дамжин орж хадгалагдан улмаар үхлийн шалтгаан болдог. Жишээ нь: 2002 оны 4 сард Английн Далай тэнгисийг хамгаалах нийгэмлэгээс гаргасан тайланд Нормандийн эрэг хавиас олдсон халимны ходоодноос 800 кг гялгар уут авсан байхад Японы эрэг хавиас далайн яст мэлхий болон загасны ходоодноос ихээхэн хэмжээний гялгар уут гаргаж байгаа талаар байнга мэдээлсээр байна.



Ахин боловсруулах эргэлтийн хугацаа удаантай:

- Ахин боловсруулалтын хүчин чадал бий болоогүй байна.
- Хог ангилан ялгалт шаардлагын түвшинд хийгддэггүй.



Талбай их эзэлдэг хог хаягдлын тоонд ордог:

- Хэдийгээр хөнгөн мэт боловч булахад зай их эзэлдэг.
- Газар нь үл сэргээгдэх байгалийн баялаг учир ойрын ирээдүйд хогийн цэгийн зориулалтаар ашиглах газаргүй болох аюул бусад өндөр хөгжилтэй орнуудын нэгэн адил нүүрлэх нь.



Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн эрхэм зорилго нь ах дэлхийн байгаль орчны доройтлыг зогсоож, хүн төрөлхтөн байгальтайгаа харилцан шүтэлцжэ амьдрах ирээдүйг бүтээхэд оршино.

for a living planet™

Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн
Монгол дахь хөтөлбөрийн газар
Амарын гудамж-4, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо
Улаанбаатар, Монгол Улс
Утас: +976-11-311659; Факс: +976-11-310237
И-мэйл: info@wwf.mn; Website: www.wwf.mn
www.panda.org



Шведийн Олон Улсын Хөгжлийн Хамтын Ажиллагааны Агентадее (SIDA)-ийн санхүүжилтээр энэхүү сонинг хэвлүүлэв.

Дугаар багтсан: Ч. Здренчичаг

Хичээл: Г. Содномваланга

Хэвлэл: Уйрморь кооператив газар

